

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2021/27/СТА-ТЕЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2021 он

Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчийн албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663
Цахим хаяг: Naranchimegts@audit.gov.mn

Аудитын дөрөвдүгээр газрын захирал,
тэргүүлэх аудитор: Я.Самбууням
Утас: 260949
Цахим хаяг: Sambuunyamyа@audit.gov.mn

Аудитын менежер: Ц.Хосжаргал
Утас: 261628
Цахим хаяг: Khosjargalts@audit.gov.mn

Аудитор: Г.Түвшинзаяа
С.Бат-эрдэнэ
Утас: 260512
Цахим хаяг: Tuvshinzayag@audit.gov.mn
Baterdenes@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	4
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал.....	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	18
3.8 Аудитын гол асуудал	18
3.9 Шилэн дансны мэдээлэл	19
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
4. Аудитын илрүүлэлт	19
5.Менежментийн захидал.....	19
6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	22
7. Төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ДЦС-2	Дулааны хоёрдугаар цахилгаан станц
ДЦС-3	Дулааны гуравдугаар цахилгаан станц
ДЦС-4	Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц
ДДЦС	Дарханы дулааны цахилгаан станц
ЭДЦС	Эрдэнэтийн дулааны цахилгаан станц
УБЦТС	Улаанбаатарын цахилгаан түгээх сүлжээ
БЗӨБЦТС	Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ
ДБЭХС	Дорнод бүсийн эрчим хүчний систем
ЦДҮС	Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ
ДДС	Дарханы дулааны сүлжээ
БДС	Багануурын дулааны станц
НДС	Налайхын дулааны станц
ББЭХС	Баруун бүсийн эрчим хүчний систем
АУЭХС	Алтай-Улиастайн эрчим хүчний систем
ДҮТ	Диспетчерийн үндэсний төв
ДШГ	Дулаан Шарын гол
ӨБЦТС	Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ
УБДС	Улаанбаатар дулааны сүлжээ
АДС	Амгалан дулааны станц
ЭГУЦС	Эгийн голын усан цахилгаан станц
ЭБЦТС	Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ
УДС	Увсын дулааны станц
ХДС	Ховдын дулааны станц
ХөДС	Хөвсгөл дулааны станц
ЭХЭЗХ	Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн
ЭХХТ	Эрчим хүчний хөгжлийн төв
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо
СЭХҮТ	Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД
Н.ТАВИНБЭХ ТАНАА

2021.04.26 № 1320
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 39,771.8 сая төгрөгийн залруулаагүй алдаа зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнийг давж, холбогдох хууль, журамд нийцээгүй, санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал”, “ Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

Д.ЗАНДАНБАТ

2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

		/мянган төгрөгөөр/	
Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	624,014,122.4	558,502,256.7
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	46,879,637.3	32,954,998.0
33	АВЛАГА	82,381,823.1	135,196,615.8
34	УРЬДЧИЛГАА	107,315,862.7	41,838,749.3
35	БАРАА МАТЕРИАЛ	112,900,729.7	124,474,252.3
36	НӨӨЦИЙН БАРАА	1,807,961.8	1,700,461.2
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	272,728,107.9	222,337,180.1
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,123,703,955.2	3,589,776,613.7
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	7,851,950.9	1,141,535.8
37300	Урт хугацаат зээл	7,851,950.9	1,141,535.8
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,115,852,004.2	3,588,635,077.9
39200	Биет хөрөнгө	2,838,729,610.1	3,286,573,747.4
39300	Биет бус хөрөнгө	267,370,964.6	298,610,692.7
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	9,751,429.6	3,450,637.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,747,718,077.6	4,148,278,870.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,197,939,567.2	1,656,169,043.8
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	183,948,591.1	262,510,117.3
41200	Богино хугацаат зээлийн өглөг	38,038,115.2	59,676,426.7
41300	Өглөг	118,084,457.8	180,740,988.5
41400	Урьдчилж орсон орлого	27,826,018.0	22,092,702.1
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,013,990,976.2	1,393,658,926.5
42200	Урт хугацаат зээл	1,013,990,976.2	1,393,658,926.5
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,549,778,510.4	2,492,109,826.6
51	Засгийн газрын хувь оролцоо	2,549,778,510.4	2,492,109,826.6
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,271,431.5	3,271,431.5
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	1,287,182,485.3	1,292,445,566.6
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	295,052,854.1	422,381,787.0
51200	Хуримтлагдсан үр дүн	63,835,488.9	-167,331,595.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	900,436,250.5	941,342,636.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,747,718,077.6	4,148,278,870.4

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	455,477,808.7	341,453,375.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	337,868,844.6	265,333,797.8
120	Нийтлэг татварын бус орлого	337,868,844.6	265,333,797.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	117,608,964.0	76,119,577.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	403,431,136.4	467,456,945.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	403,431,136.4	467,456,945.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	383,715,473.6	465,953,834.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,709,464.5	1,884,552.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	216,893.6	264,034.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	133,870.8	74,744.6
2104	Хангамж, бараа материалын зардал	83,902.5	75,552.0
2105	Нормативт зардал	2,712.0	1,378.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,747.0	2,909.9
2107	Томилолт, зочны зардал	73,313.1	3,313.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	208,580,296.0	265,985,045.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	172,888,274.1	197,662,304.5
211	ХҮҮ	2,493,909.5	-
212	ТАТААС	17,150,000.0	1,122,144.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	71,753.3	380,966.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	52,046,672.2	-126,003,570.5
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	1,184,883.2	321,589.3
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	63,923,337.1	113,790,947.3
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-10,691,781.7	-239,472,928.5

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,610,685,986.0	2,610,685,986.0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-144,296,604.6	-144,296,604.6
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,466,389,381.4	2,466,389,381.4
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	155,312,021.3	155,312,021.3
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-86,128,961.8	-86,128,961.8
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	12,935,243.3	12,935,243.3
7	Өмчид гарсан өөрчлөлт	12,327,714.8	12,327,714.8
8	Зарласан ногдол ашиг	-365,107.0	-365,107.0
9	Тайлант үеийн үр дүн	-10,691,781.7	-10,691,781.7
10	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,549,778,510.4	2,549,778,510.4
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	8,338,592.5	8,338,592.5
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,558,117,102.9	2,558,117,102.9
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	83,338,956.4	83,338,956.4
14	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	20,073,364.8	20,073,364.8
15	Өмчид гарсан өөрчлөлт	70,288,131.3	70,288,131.3
16	Зарласан ногдол ашиг	-234,800.3	-234,800.3
17	Тайлант үеийн үр дүн	-239,472,928.5	-239,472,928.5
18	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,492,109,826.6	2,492,109,826.6

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

		/мянган төгрөгөөр/	
Код:	Тайлангийн үзүүлэлт	2019оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,619,166,560.7	1,558,058,454.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,501,557,596.6	1,481,838,877.4
120	Нийтлэг татварын бус орлого	1,501,557,596.6	1,481,838,877.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	117,608,964.0	76,219,577.4
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,483,283,890.0	1,595,109,200.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,483,283,890.0	1,595,109,200.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,473,982,169.6	1,593,606,089.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	231,411,050.6	272,093,828.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,489,150.4	71,058,581.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,045,038.3	29,193,192.7
2104	Хангамж, бараа материалын зардал	740,262,733.7	844,991,173.0
2105	Нормативт зардал	2,712.0	1,429.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,788.2	2,786.6
2107	Томилолт, зочны зардал	70,027.6	3,313.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	411,297,676.4	376,061,836.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	378,992.5	199,947.7
211	ХҮҮ	2,468,101.9	0.0
212	ТАТААС	800,000.0	1,122,144.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,033,618.5	380,966.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	135,882,670.7	-37,050,746.0
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	2,136,085.4	504,032.3
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	353,585,071.2	155,903,543.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	353,585,071.2	155,903,543.5
2200	Дотоод эх үүсвэрээр	353,585,071.2	155,903,543.5
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-351,448,985.8	-155,399,511.2
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	206,232,420.4	178,525,617.9
14	Бусад эх үүсвэр	255,975,894.5	222,281,071.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	49,743,474.1	43,755,453.1
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-9,333,894.7	-13,924,639.3
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	56,213,532.0	46,879,637.3
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	46,879,637.3	32,954,998.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/					
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	61,924,367,000.00	45,457,189,541.74	16,467,177,458.26	73.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	29,653,467,000.00	27,045,335,992.74	2,608,131,007.26	91.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,795,762,000.00	2,483,970,029.14	311,791,970.86	88.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,162,491,900.00	1,881,582,999.01	280,908,900.99	87.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	291,936,400.00	264,034,062.47	27,902,337.53	90.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	74,744,600.00	74,744,572.21	27.79	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	78,120,700.00	75,200,802.45	2,919,897.55	96.26
2105	Нормативт зардал	1,429,900.00	1,429,539.00	361.00	99.97
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	152,786,700.00	152,775,830.00	10,870.00	99.99
2107	Томилолт, зочны зардал	3,313,300.00	3,313,300.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,938,500.00	30,888,924.00	49,576.00	99.84
212	ТАТААС	26,765,613,800.00	24,493,958,182.00	2,271,655,618.00	91.51
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	24,420,788,000.00	24,420,788,000.00	-	100.00
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	2,344,825,800.00	73,170,182.00	2,271,655,618.00	3.12
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	92,091,200.00	67,407,781.60	24,683,418.40	73.20
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	4,400,000.00	3,495,036.00	904,964.00	79.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	87,691,200.00	63,912,745.60	23,778,454.40	72.88
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	32,270,900,000.00	18,411,853,549.00	13,859,046,451.00	57.05
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	61,924,367,000.00	45,457,189,541.74	16,467,177,458.26	73.41
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	61,924,367,000.00	45,457,189,541.74	16,467,177,458.26	73.41
310001	Улсын төсвөөс санхүүжих	61,924,367,000.00	45,457,189,541.74	16,467,177,458.26	73.41
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	95	89	6.00	93.68
620001	Удирдах ажилтан	13	12	1.00	92.31
620002	Гүйцэтгэх ажилтан	68	63	5.00	92.65
620003	Үйлчлэх ажилтан	14	14	-	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	95	89	6.00	93.68
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	78	73	5.00	93.59
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	4	-	4.00	-
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11	14	-3.00	127.27
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	2	2	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/		
Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,567,028,180.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,567,028,180.00
212	ТАТААС	12,567,028,180.00
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	12,567,028,180.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	12,567,028,180.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12,567,028,180.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,567,028,180.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,567,028,180.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчилж мөрдүүлэх, төсвийн ерөнхийлөн захирагчийн хуульд заасан үүрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Аудитын хоёрдугаар газрын аудитор Г.Түвшинзаяа, С.Бат-эрдэнэ нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Ц.Хосжаргал, аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн В/1172 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Эрчим хүчний яамны үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн өсөлтийг хангахуйц эрчим хүчний бодлогыг хэрэгжүүлж, хүний эрүүл, аюулгүй, тав тухтай орчинд амьдрах болон үйлдвэрлэл, үйлчилгээний найдвартай, тогтвортой нөхцөлийг хангахад оршино” гэж тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Коронавируст халдварын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай” 211 дугаар тогтоолын өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар нь тайлант онд төлөвлөгөөт 9 ажил, төлөвлөгөөт бус 10 ажил хийхээр төлөвлөж, гүйцэтгэлээр харьяа 12 байгууллагын үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитаар илрүүлсэн 4,659.7 сая төгрөгийн 99 зөрчилд зөвлөмж өгч ажилласан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлангийн нийт зардал 1,794,768.2 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 35,895.4 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 46,879.6 сая, эцсийн үлдэгдэл 32,955.0 сая төгрөг болж, 13,924.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	387.4	227.8	-159.6	1.2
Банканд байгаа бэлэн мөнгө	46,400.2	32,695.8	-13,704.4	98.4
Замд яваа мөнгөн хөрөнгө	92.0	31.4	-60.6	0.4
Дүн	46,879.6	32,955.0	-13,924.6	100.0

Эх сурвалж: Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс 6,714.3 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд, 25,981.5 сая төгрөг арилжааны банкны дансанд, үүнээс 5,998.2 сая төгрөг барьцаа дансанд байршиж байна.

Аудитын илрүүлэлт:

- УБЦТС ТӨХК Мөнгөн хөрөнгийн кассын зарлагын гүйлгээ хийх дээд хязгаарыг давсан нийт 54.1 сая төгрөгийн гүйлгээ хийсэн;
- Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн /ДЦС-3 ТӨХК 510.6 сая, ЭХХТ ТӨХК 184.6 сая, Багануурын ДЦС ТӨХК 55.7 сая, Увсын ДС ТӨХК 57.7 сая, Хөвсгөл ДС ТӨХК 33.3 сая, Алтай улиастай эрчим хүчний систем ТӨХК 11.6 сая, Тавантолгой цахилгаан станц ХХК 0.7 сая/.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 82,381.3 сая, эцсийн үлдэгдэл 135,196.6 сая төгрөг болж, 52,814.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	3.5	1.0	-2.5
Төлбөртэй үйлчилгээний авлага	19.3	-	-19.3
Дансны авлага	69,735.2	103,352.4	33,617.2
Татвар, НДШ-ийн авлага	3,568.4	4,166.6	598.2
Бусад авлага	9,055.4	27,676.6	18,621.2
Дүн	82,381.8	135,196.6	52,814.8

Эх сурвалж: Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэл 135,196.6 сая төгрөгөөр буюу өмнөх оноос 52,814.8 сая төгрөгөөр өссөн нь Дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас эдийн засгийн өсөлт удааширч, иргэдийн төлбөрийн чадвар буурсантай холбоотойгоор Төрийн өмчит компаниудын цахилгаан эрчим хүчний төлөлт буурсан, Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолоор цахилгааны төлбөрийг чөлөөлөх болсонтой холбоотойгоор 12 дугаар сарын цахилгааны авлага барагдаагүйгээс шалтгаалсан байна. Тухайлбал: УБЦТС ТӨХК 22,737.2 сая төгрөгөөр, ДЦС 4 ТӨХК 16,419.3 сая төгрөгөөр, ЭБЦТС ТӨХК 3,541.8 сая төгрөгөөр, Эрдэнэтийн ДЦС 3,429.6 сая төгрөгөөр, БЗӨБЦТС ТӨХК 2,209.2 сая төгрөгөөр тус тус голлон нэмэгдсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Шүүх хяналтын байгууллагаар авлага барагдуулах шийдвэр гарсан ч тайлант хугацаанд авлагыг барагдуулаагүй /Дулаан шарын гол ТӨХК 177.9 сая, Багануурын ДС ТӨХК 22.7 сая/;
- Он дамжсан авлагыг барагдуулаагүй /АУЭХС ТӨХК 53.1 сая, УБДС ТӨХК 31.0 сая, Ховдын ДС 27.9 сая/;
- Нийт 237.4 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй /ДЦС-3 ТӨХК 129.4 сая, ДЦС- 4 ТӨХК 45.2 сая, УБЦТС ТӨХК 62.8 сая/.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 107,315.9 сая, эцсийн үлдэгдэл 41,838.7 сая төгрөг болж, 65,477.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3. Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	104,273.6	41,731.6	-62,542.0
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	52.3	56.1	3.8
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	2,990.0	51.0	-2,939.0
Дүн	107,315.9	41,838.7	-65,477.2

Эх сурвалж: Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилж гарсан зардал дансны их хэмжээний үлдэгдэлтэй байгууллагуудыг дурдвал:

- Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХК-ийн дансны үлдэгдэл 14,628.3 сая төгрөг нь өмнөх төслийн нэгжээс шилжиж ирсэн үлдэгдэл бөгөөд уг урьдчилгаа төлбөр нь 2013-2017 онуудад ТЭЗҮ, зураг төсөл, усны нөөц хангамжийн судалгаа, нүүрсний шинжилгээ, олон улсын хууль эрх, санхүүгийн болон техникийн зөвлөх үйлчилгээ, геологи, геодезийн судалгаа, кадастрын судалгаа зэрэг ажлын зардлыг хуримтлуулан бүртгэсэн ба цаашид цахилгаан станцын өртөгт шилжих хөрөнгө;
- Эгийн голын усан цахилгаан станц ТӨХК-ийн дансны үлдэгдэл 12,152.3 сая төгрөг болж 922.8 сая төгрөгөөр өссөн нь Биологийн олон янзын байдлын нэмэлт судалгааны гэрээний урьдчилгааны төлбөртэй холбоотой ба гэрээний ажил 2021 онд үргэлжлэн хийгдэхээр болсон байна.

3.5.4 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын эхний үлдэгдэл 7,852.0 сая, эцсийн үлдэгдэл 1,141.5 сая төгрөг болж, 6,710.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4. Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урт хугацаат зээл	7,852.0	1,141.5	-6,710.5
Дүн	7,852.0	1,141.5	-6,710.5

Эх сурвалж: Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урт хугацаат хөрөнгө оруулалтын дансанд Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК болон Сангийн яамны хооронд 2006 оны 8 дугаар сарын 17-ны өдөр байгуулагдсан "Эрчим хүчний хэмнэлтийн төсөл"-ийн "1492 MON(SF)" дугаартай 26 тоот Дамжуулан зээлдүүлэх гэрээний үлдэгдэл 3,896.4 сая төгрөг, 2013 оны 5 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан "Дулааны үр ашгийн төсөл"-ийн "1548-MON(SF)" дугаартай 20 тоот зээлийн гэрээний үлдэгдэл 13,231.8 сая төгрөгийг тусгасан байна. Тайлант онд 1,016.2 сая төгрөгийн зээлийн үндсэн төлбөрийг төлсөн байна.

3.5.5 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 112,900.7 сая, эцсийн үлдэгдэл 124,474.3 сая төгрөг болж, 11,573.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5. Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	30,932.0	25,868.4	-5,063.6
Тусгай зориулалттай материал	30,903.4	25,860.0	-5,043.4
Эм боох материал	28.6	8.4	-20.2
Дуусаагүй үйлдвэрлэл	4,190.3	2,520.9	-1,669.4
Бэлэн бүтээгдэхүүн	1,666.5	7,584.1	5,917.6
Хангамжийн материал	76,036.2	88,313.3	12,277.1
Бичиг хэргийн материал	513.5	382.9	-130.6
Аж ахуйн материал	2,043.0	1,972.3	-70.7
Сэлбэг хэрэгсэл	36,827.4	42,643.5	5,816.1
Түлш, шатах тослох материал	16,190.2	13,799.8	-2,390.4
Барилгын засварын материал	6,895.5	6,699.9	-195.6
Хүнсний материал	129.7	226.4	96.7
Бусад хангамжийн материал	13,437.0	22,588.5	9,151.5
Мал амьтад	75.7	187.6	111.9
Дүн	112,900.7	124,474.3	11,573.6

Эх сурвалж: Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл 11,573.6 сая төгрөгөөр өсөхөд бэлэн бүтээгдэхүүн 5,917.6 сая, хангамжийн материал 12,271.3 сая төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

Үүнээс "Таван толгой түлш" ХХК-ийн бараа материал өмнөх оноос 13,579.8 сая төгрөгөөр өссөн нь сайжруулсан шахмал түлшний түүхий эдийн эд материал болох мидлинг болон барьцалдуулагчийн үлдэгдэл өссөнөөс шалтгаалжээ.

Аудитын илрүүлэлт:

- Бараа материалын дансанд үндсэн хөрөнгө бүртгэсэн, ашиглалтгүй болсон бараа материал бүртгэлтэй /ЭБЦТС ТӨХК 893.7 сая, Багануурын дулааны станц ТӨХК 9.0 сая, Тавантолгой түлш ХХК 97.1 сая, УБДС ТӨХК 26.9 сая/;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөөгүй, барааны худалдан авалт хийсэн /УБЦТС ТӨХК 736.7 сая, ДЦС-4 ТӨХК 255.0 сая, ЦДҮС ТӨХК 215.0 сая, ЭБЦТС ТӨХК 231.3 сая, АДС ТӨХК 121.9/.

3.5.6 Нөөцийн БАРАА

Нөөцийн бараа материалын эхний үлдэгдэл 1,808.0 сая, эцсийн үлдэгдэл 1,700.5 сая төгрөг болж, 107.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №6. Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
НӨӨЦИЙН БАРАА	1,808.0	1,700.5	-107.5
Барааны нөөц	1,808.0	1,700.5	-107.5
Дүн	1,808.0	1,700.5	-107.5

Эх сурвалж: Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нөөцийн бараа материалын үлдэгдэлд тайлант оны эцэст 1,700.5 сая төгрөгийн мазут, нүүрс гэх мэт түүхий эд материалыг гэнэтийн дулааны эрчим хүч алдагдах шалтгаанаар нөөцөлсөн байна. Тухайлбал: ДБЭХС ТӨХК 404.2 сая, ДЦС-4 ТӨХК 968.3 сая, УБДС ТӨХК 246.7 сая, Хөвсгөл дулааны станц ТӨААТҮГ 78.4 сая төгрөгийн нөөцийн барааны үлдэгдэл байна.

3.5.7 Бусад эргэлтийн хөрөнгө

Бараа материалын эхний үлдэгдэл 272,728.1 сая, эцсийн үлдэгдэл 222,337.2 сая төгрөг болж, 50,390.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №7. Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	272,728.1	222,337.2	-50,390.9
Бусад эргэлтийн хөрөнгө	272,728.1	222,337.2	-50,390.9
Дүн	272,728.1	222,337.2	-50,390.9

Эх сурвалж: Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл 50,390.9 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд Эрчим хүчний яам 74,324.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг улсын комисс хүлээж авч, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгснөөс голлож буурсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон ашиглагч байгууллагад шилжүүлээгүй 222,337.2 сая төгрөгийн улсын комиссын акт гараагүй хөрөнгө оруулалтын ажил бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлтэй байна.

3.5.8 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 3,115,852.0 сая, эцсийн үлдэгдэл 3,588,635.0 сая төгрөг болж, 472,783.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	2,838,729.6	3,286,573.7	447,844.1
Биет бус хөрөнгө	267,371.0	298,610.7	31,239.7
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	9,751.4	3,450.6	-6,300.8
Дүн	3,115,852.0	3,588,635.0	472,783.0

Эх сурвалж: Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 69,169.7 сая, балансаас балансад шилжүүлэн авсан 107,257.6 сая, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлж авсан 81,791.0 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 66,880.5 сая, бусад эх үүсвэрээр бэлтгэсэн 719,143.7 сая, дахин үнэлгээний нэмэгдэл 107,610.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, балансаас балансад шилжүүлсэн 31,081.1 сая, худалдсан 151.6 сая, акталсан 19,120.8 сая, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн 85,172.7 сая, бусад 299,045.7 сая, дахин үнэлгээний хорогдол 78,298.4 сая төгрөгөөр тус тус хасагдсан байна.

Дуусаагүй барилга дансанд 81,458.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь барилга, байгууламжийг хүлээж авах улсын комиссын акт, ашиглагч байгууллагад шилжүүлэх шийдвэр гараагүйгээс барилгууд бүртгэлтэй хэвээр байна. Тухайлбал: Таван толгой түлш ХХК 44,441.7 сая, ДЦС-3 ТӨХК 12,782.9 сая, ЭБЦТС ТӨХК 9,680.6 сая, БЗӨБЦТС ТӨХК 8,151.1 сая, ЭХХТ ТӨХК 3,799.5 сая, ЭХЯ 2,323.8 сая төгрөгийн дуусаагүй барилга байна.

Эрчим хүчний яамны дуусаагүй барилга, байгууламжийн дансанд улсын хөрөнгө оруулалтаар бий болсон “Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэгт байрлалтай хуваарилах байгууламж №7-ийн хүчин чадлын нэмэгдүүлж өргөтгөх барилга угсралтын ажил”-ыг ашиглалтад оруулах техникийн комисс ажиллаж 2011 оны 174/2011 дугаартай акт үйлдэн хүлээн авсан боловч газрын маргаанаас шалтгаалж барилга дансанд шилжүүлээгүй 1,481.6 сая төгрөгийн барилга бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл аль хөрөнгөд хамаарах нь тодорхойгүй /УБЦТС ТӨХК 9,378.8 сая/;
- Бараа материалын шинж чанартай хөрөнгийг бүртгэсэн, ашиглагдах жилийг оруулаагүйгээс элэгдэл тооцоогүй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийг дахин үнэлээгүй, үндсэн хөрөнгө дансанд бүртгэлгүй зардалд шууд бүртгэсэн. /ЭБЦТС ТӨХК 893.7 сая, Тавантолгой түлш ХХК 465.8 сая, Багануурын дулааны станц ТӨХК 12.8 сая, ДЦС-2 ТӨХК 26.5 сая/;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй, худалдан авалт хийсэн /БЗӨБЦТС ТӨХК 1,162.2 сая, ЭБЦТС ТӨХК 84.2 сая/.

3.5.9 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 1,197,939.6 сая, эцсийн үлдэгдэл 1,656,169.0 сая төгрөг болж, 458,229.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №9. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	183,948.6	262,510.1	78,561.5	17.1
Богино хугацаат зээлийн өглөг	38,038.1	59,676.4	21,638.3	4.7
Өглөг	118,084.5	180,741.0	62,656.5	13.6
Урьдчилж орсон орлого	27,826.0	22,092.7	-5,733.3	-1.2
Урт хугацаат өр төлбөр дүн	1,013,991.0	1,393,658.9	379,667.9	82.9
Урт хугацаат зээл	1,013,991.0	1,393,658.9	379,667.9	82.9
Төгрөг	727,230.7	1,064,815.8	337,585.1	73.7
Гадаад валют	286,760.3	328,843.1	42,082.8	9.2
Нийт дүн	1,197,939.6	1,656,169.0	458,229.4	100.0

Эх сурвалж: Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл өмнөх оноос 78,561.5 сая төгрөгөөр өссөн нь богино хугацаат зээлийн өглөг 21,638.3 сая, өглөг 62,656.5 сая төгрөгөөр нэмэгдсэн бол урьдчилж орсон орлого 5,733.2 сая төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна. Тус дансны үлдэгдлийн 5,998.2 сая төгрөг барьцаа дансны өглөг байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 1,393,658.9 сая төгрөг болж өмнөх оноос 379,667.9 сая төгрөгөөр өссөн байна.

Урт хугацаат өр төлбөрийн их хэмжээний өсөлттэй байгууллагуудыг дурдвал:

- Тавантолгой түлш ХХК 138,725.0 сая төгрөгөөр өссөн нь Эрдэнэс таван толгой ХК-ийн тайлант хугацаанд олгосон эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүжилт нэмэгдсэн;
- Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК 112,969.1 сая төгрөгөөр өссөн нь Сангийн яам, Хөгжлийн банкнаас авсан шинэчлэлтийн төслийн зээл;
- Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК 78,701.1 сая төгрөгөөр өссөн нь ХБНГУ-ын “Эрчим хүчний хөтөлбөр” төслийн зээл, Шведийн олон улсын хөгжлийн агентлагийн хөнгөлөлттэй зээл, Азийн хөгжлийн банкны зээл, Япон Улсын зээл;
- Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК 11,320.7 сая төгрөгөөр өссөн нь “Эрчим хүчний төсөл-2” төслийн зээл 2020 онд 1,746,803.78 ам.доллаароор нэмэгдэж, оны эцэст 4,266,034.25 ам.доллар буюу 12,156.1 сая төгрөг болсон;
- Дарханы дулааны цахилгаан станц ТӨХК 10,011.9 сая төгрөгөөр өссөн нь турбин генератор 5 төслийн зээлийн өглөг дансны валютын ханшийн өөрчлөлттэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Нийт 3,803.6 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй /УБЦТС ТӨХК 3,691.4 сая, ДЦС 3 ТӨХК 104.6 сая, ХөДС ТӨХК 7.6 сая/.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 2,549,778.5 сая, эцсийн үлдэгдэл 2,492,109.8 сая төгрөг болж, 57,668.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 10. Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,271.4	3,271.4	-	-
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	1,287,182.5	1,292,445.6	5,263.1	9.1
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	295,052.9	422,381.8	127,328.9	220.8
Хуримтлагдсан үр дүн	63,835.5	-167,331.6	-231,167.1	-400.8
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	900,436.2	941,342.6	40,906.4	70.9
Дүн	2,549,778.5	2,492,109.8	-57,668.7	-100.0

Эх сурвалж: Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл буурсан нь төрийн өмч, эздийн өмчийн бусад хэсэг, хуримтлагдсан үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүгээс шалтгаалжээ. Үүнд:

Төрийн өмчийн дансны үлдэгдэл 1,292,445.6 сая төгрөг болж 5,263.1 сая төгрөгөөр өссөн нь УДС ТӨХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2020 оны 5 дугаар тогтоолоор 12,935.2 сая, ДДС ТӨХК-ийн ТУЗ-ийн хурлын 2020 оны 4 дүгээр тогтоолоор 7,701.4 сая, ТӨБЗГ-ын 2019 оны 283 дугаар тогтоолоор 620.1 сая, ӨБЦТС ТӨХК нь ТӨБЗГ-ын 2019 оны 327 дугаар тогтоолоор 1,243.4 сая, ББЭХС ТӨХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 5 дугаар тогтоолоор 1,133.1 сая төгрөгөөр тус тус төрийн өмчийн дүнг нэмэгдүүлж, ДБЭХС ТӨХК-ийн эздийн өмчийн бусад хэсэгт бүртгэх байсан хөрөнгийг төрийн өмчид бүртгэсэн байсныг залруулж 18,204.2 сая, ЭХЗХ ТӨХК нь бүтцийн өөрчлөлтөөр тухайн ТЕЗ-д харьяалагдахгүй болсон тул 104.5 сая төгрөгөөр тус тус төрийн өмчийг бууруулсан байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 941,342.6 сая төгрөг болж 40,906.4 сая төгрөгөөр өссөн нь ДЦС-3 ТӨХК тайлант онд 2,205 нэр төрлийн тоног төхөөрөмжийг дахин үнэлж бүртгэлд тусгаснаар 48,624.1 сая төгрөгөөр дахин үнэлгээний дүнг нэмэгдүүлж, АУЭХС ТӨХК тайлант онд ТӨБЗГ-ын 2020 оны 44 тоот шийдвэрийн дагуу 2018 онд зөрүүтэй бүртгэсэн байсан 11,033.2 сая төгрөгийн хөрөнгийг залруулан бүртгэж бууруулсан нь голлон шалтгаалжээ.

Эздийн өмчийн бусад хэсэг дансны үлдэгдэл 422,381.8 сая төгрөг болж 127,328.9 сая төгрөгөөр өссөн нь УБЦТС ТӨХК 42,951.5 сая, ДЦС-4 ТӨХК 29,239.0 сая, БЗӨБЦТС ТӨХК 27,543.2 сая төгрөг, ДБЭХС ТӨХК 20,927.0 сая төгрөгийн хөрөнгө тус тус нэмэгдсэнээс голлон шалтгаалжээ.

Хуримтлагдсан үр дүн 167,331.6 сая төгрөгийн хасах үлдэгдэлтэй болж өмнөх оноос 231,167.1 сая төгрөгөөр буурсан нь харьяа төрийн өмчит 24 компани алдагдалтай ажилласнаас шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг болон нийт зарлагыг 297,456.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 254 дүгээр тогтоолоор Эрчим хүчний сайдын 2020 оны төсвийн хязгаарыг 65,352.9 сая төгрөгөөр баталсан ба төсвийн ерөнхийлөн захирагчийн боловсруулж хүргүүлсэн төсвийн төслийг

235,532.5 тэрбум төгрөгөөр бууруулж 61,924.4 сая төгрөгөөр баталсан байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн боловсруулсан төсвийн төслийг төсвийн хязгаарт багтаах, 2020 оны тэвчиж болох зардлыг танах бодлого чиглэлийн дагуу бууруулсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрт зориулан 61,924.4 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 29,653.5 сая төгрөгийг урсгал зардалд, 32,270.9 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулах, эх үүсвэрийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс нийт 45,457.2 сая төгрөгийн санхүүжилт олгож, 16,467.2 сая төгрөгөөр дутуу санхүүжигдсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 45,457.2 сая төгрөг буюу 73.4 хувьтай байгаа нь хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас, хөрөнгө оруулалтын зардлыг дутуу санхүүжүүлснээс шалтгаалсан байна.

Хөрөнгө оруулалтын 30 төсөл, арга хэмжээнд 32,270.9 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 18,411.9 сая төгрөгийн санхүүжилт олгож, 1,135.9 сая төгрөгийг барьцаа дансанд, 174.7 сая төгрөгийг захиалагчийн хяналтын дансанд төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас “гэр хорооллын өрхөд шөнийн цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлтийн татаас” 12,567.0 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийн олгогдсоноос 14 төрийн өмчит болон бусад компаниудад хуваарилан шилжүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Коронавируст халдварын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай” 211 дугаар тогтоолын 1-д “Айл өрхийн болон дор дурдсанаас бусад аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөр, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс тооцож 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд төрөөс хариуцан төлөх арга хэмжээг зохих журмын дагуу авч хэрэгжүүлэхийг ... нарт тус тус даалгасугай” гэж заасны дагуу оны эцэст эрчим хүчний цахилгаан, дулааны төлбөрийг Засгийн газраас төлөхөөр шийдвэрлэсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд Эрчим хүчний сайдын 2020 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн тоон болон чанарын хүрэх түвшинд дулааны шугам сүлжээний өргөтгөл 7.4 км 2 шинэ ажил, 70 халаалтын зуухыг буулгаж төвлөрсөн дулаан хангамжид холбох, Улаанбаатар хотын цахилгаан хангамжийн дамжуулах, түгээх сүлжээний өргөтгөл, шинэчлэлт хийж 6103 айл өрхийг цахилгаантай болох, орон нутгийн цахилгаан хангамжийн дамжуулах, түгээх сүлжээний өргөтгөл, шинэчлэлтийн хүрээнд 30 сумыг хамруулахаар баталснаас хэрэгжилтийг 90.0 хувьтай гэж тайлагнасан байна.

3.9 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд 150 мэдээлэл байршуулахаас 146 мэдээллийг хугацаанд нь, хугацаа хоцроож 2 мэдээллийг байршуулсан байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 445.3 сая төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт тогтоож, 4,204.1 сая төгрөгийн зөрчилд 23 албан шаардлага, 8,883.3 сая төгрөгийн зөрчилд 115 зөвлөмж өгсөн байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /сая.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Гүйцэтгэлийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт	5	445.3	5	445.3	100.0
Албан шаардлага	23	4,204.1	22	4,107.9	83.9
Зөвлөмж	115	8,883.3	110	8,883.3	82.5
Нийт дүн	143	13,532.7	137	13,436.5	88.8

3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал

Ковид-19 цар тахлын хөл хорионы улмаас тухайн байгууллага дээр ажиллах боломж хязгаарлагдмал байсан тул худалдан авах ажиллагааг гүйцэтгэлийн аудитаар хамруулах нь зүйтэй.

4. Аудитын илрүүлэлт

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 32 тайланг нэгтгэснээс санхүүгийн тайланд Зөрчилгүй 23, Хязгаарлалттай 8 дүгнэлт өгч, 1 байгууллагыг түүвэрт хамруулсан байна.

4.1 Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа БЗӨБЦТС ТӨХК, Даланзадгадын ДЦС ТӨХК, ДҮТ ТӨХК, ДБЭХС ТӨХК, ДШГ ТӨХК, УБЦТС ТӨХК, Эгийн голын усан цахилгаан станц ТӨХК, ЭХЭЗХ ТӨХК-ууд “хязгаарлалттай” дүгнэлт авсан байна.

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 83,895.8 сая төгрөгийн 77 алдааг аудитын явцад залруулж, залруулагдаагүй нийт 63,359.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 85.2 сая төгрөгийн зөрчилд 11 төлбөрийн акт тогтоож, 16,701.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 44 албан шаардлага хүргүүлж, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 23,588.0 сая төгрөгийн 18 албан шаардлага хүргүүлж, 22,984.8 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 126 зөвлөмж өгсөн байна.

4.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

5. Менежментийн захидал

5.1 Татаас, санхүүжилттэй холбоотой асуудал

5.1.1 Илрүүлэлт:

Засгийн газрын 2017 оны 199 дүгээр тогтоолоор баталсан “Гэр хорооллын өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлэх журам”-ын хүрээнд Эрчим хүчний зохицуулах хорооноос баталсан тарифын хөнгөлөлтийг үндэслэн 2017 оноос гэр

хорооллын айл өрхүүдэд хөнгөлөлт үзүүлж, санхүүжилтийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын агаар, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээний хөтөлбөрөөс олгож ирсэн байна. Орчны бохирдол бууруулах үндэсний хорооноос уг арга хэмжээний төсвийг жил бүр баталж, санхүүжилтийг баталсан төсвийн хүрээнд олгож ирсэн боловч гүйцэтгэлээр зардал жил бүр хэтэрч, 2020 оны жилийн эцсийн байдлаар төрийн өмчит эрчим хүчний 14 компанид өгөх 7,319.5 сая төгрөгийн өр төлбөрийн хуримтлагдсан тооцоо судалгаа байна. Дээрх авлага, өр төлбөрийн үлдэгдлийг БОАЖЯ-тай тооцоо нийлж, гарын үсгээр баталгаажуулаагүй, санхүүгийн тайланд тусгаагүй байна.

5.1.2 Өгсөн зөвлөмж:

Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран ажиллаж, авлага, өглөгийн тооцоо нийлэх, татаас санхүүжилтийг бодитой олгох, шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллах

5.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

5.2.1 Илрүүлэлт:

Эрчим хүчний салбарын хэмжээнд мөрдөж байгаа НБББББ-ийн 15-д өртөг, зардал тооцох аргыг тусгасан боловч харьяа байгууллагууд үйл ажиллагааны онцлогт тохируулан ашигладаггүй, эрчим хүч үйлдвэрлэдэг болон дамжуулдаг байгууллагууд өртөг, зардлаа буруу тооцоолсон, борлуулсан бүтээгдэхүүний өртгийг тооцохдоо ерөнхий удирдлагын зардал болон бусад зардлыг шингээж стандартын дагуу өртгийг тооцоолоогүй буруу тайлагнасан нийтлэг зөрчил илэрсэн.

5.2.2 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг харьяа газруудаараа мөрдөж ажиллуулах мөн шинэчлэлт хийх

5.3 Дээд түвшний удирдлагатай холбоотой асуудал

5.3.1 Илрүүлэлт:

Харьяа төрийн өмчит компаниудын ажиллагсдад олгох нэмэгдэл хөлс, урамшуулал олгох журам нь нийтлэг биш, зарим байгууллагын журамд шалгуурыг нарийвчлан тогтоогүйгээс шагнал урамшууллыг буруу тооцоолж, олгодог асуудал арилахгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Эрхэлсэн салбар, хүрээний төрийн өмчит хуулийн этгээдийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, захиалга, төлөвлөлт, хөрөнгө оруулалт, шаардлагатай бусад асуудлаар санал боловсруулж холбогдох газарт оруулна” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

5.3.2 Өгсөн зөвлөмж:

Салбарын хэмжээний ажиллагсдад нэмэгдэл хөлс, урамшуулал олгох журмыг шинэчлэн боловсруулж, мөрдүүлэх

5.4 Дээд түвшний удирдлагатай холбоотой асуудал

5.4.1 Илрүүлэлт:

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт залруулагдаагүй 39,771.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14 дүгээр зүйлийн 14.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, ..., Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

5.4.2 Өгсөн зөвлөмж:

Харьяа байгууллагуудын үйл ажиллагааны үр өгөөжийг дээшлүүлэхэд анхаарч, удирдлага, байгууллагын дотоод аудит, санхүүгийн ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх

5.5 Дээд түвшний удирдлагатай холбоотой асуудал

5.5.1 Илрүүлэлт:

Диспетчерийн үндэсний төв ТӨҮГ-ын хөрөнгөөр ЭХЯ-ын барилгын их засвар хийлгэж, үндсэн хөрөнгө бэлтгэн төсвөөс гадуур зардал гаргасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.4-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах", 14.2.5-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

5.5.2 Өгсөн зөвлөмж:

Цаашид тус зөрчлийг давтан гаргахгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Харьяа байгууллагууд	Дүгнэлтийн хэлбэр				Төлбөрийн акт		Албан шаардлага /ШД орохгүй/		ШД хуулийн хэрэгжилтэд өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн ерөнхийлөн захирагч													
1	Эрчим хүчний сайд		1									5	
	ДҮН		1									5	
Төрийн өмчит үйлдвэрийн газар													
2	АУЭХС ТӨХК	1				1	5.7	3	144.6	1		3	18.2
3	АДС ХХК	1				1	10.0	3	127.2			4	883.6
4	БЗӨБЦТС ТӨХК		1			1	4.6	2	1,585.7	1	569.5	4	3.5
5	БДС ТӨХК	1						1	22.7	1		8	114.6
6	ББЭХС ТӨХК	1				2	0.8	2	12.6	1		7	315.9
7	Даланзадгадын ДЦС ТӨХК		1			1	3.6	2	339.3	1		1	2.4
8	ДДС ТӨХК	1								1	93.4	3	57.6
9	ДДЦС ТӨХК	1										2	1,941.3
10	ДҮТ ТӨХК		1			2	21.0	2	8,125.9	1		4	2,818.8
11	ДБЭХС ТӨХК		1					1	612.5	1		3	336.2
12	ДШГ ТӨХК		1					1	37.7	1	233.4	2	177.9
13	ДЦС-2 ТӨХК	1						1	42.7			6	95.5
14	ДЦС-3 ТӨХК	1						1	17.7			2	744.6
15	ДЦС-4 ТӨХК	1						1	255.0	1	6,604.1	5	45.2
16	НДЦС ТӨХК	1				1	0.6	1	64.2			7	12.6
17	ӨБЦТС ТӨХК	1										3	113.5
18	СЭХҮТ ТӨҮГ	1								1	356.7	3	10.7
19	Тавантолгой түлш	1						6	72.4	1		11	1,968.1
20	Тавантолгойн цахилгаан станц ХХК /4-р улирал/	1				1	0.7					4	0.3
21	УБДС ТӨХК	1										4	68.9
22	УБЦТС ТӨХК		1			1	38.2	6	4,559.7	1	15,061.2	7	9,965.5
23	УДС ТӨХК	1						1	57.7	1		1	
24	ХДС ТӨХК	1										5	31.7
25	ХөДС ТӨХК	1						1	6.3			2	40.9
26	ЦДҮС ТӨХК	1										5	277.0
27	ЭГУЦС ТӨХК		1									4	1,634.2
28	ЭБЦТС ТӨХК	1						1	231.3	1	227.5	5	1,045.3
29	ЭДЦС ТӨХК	1										3	41.9
30	Эрчим хүчний хөгжлийн төв ТӨААТҮГ	1						1		1	78.1	4	201.6
31	Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн		1					4	137.5	1		2	
	ДҮН	22	8	-	-	11	85.2	41	16,452.7	17	23,223.9	124	22,967.5
Төсвийн шууд захирагч													
32	Эрчим хүчний яам-аппарат	1						3	249.1	1	364.1	2	17.3
33	Эрчим хүчний яам-хлт												
	ДҮН	1		-	-	-		3	249.1	1	364.1	2	17.3
	Нийт дүн	23	9	-	-	11	85.2	44	16,701.8	18	23,588.0	131	22,984.8

Хавсралт

7. Төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт

	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /сая/	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
'Алтай улиастай эрчим хүчний систем ТӨХК					
1	Үндсэн үйл ажиллагааны орлого олсон боловч ажилтнуудын Хамтын санд 5.7 сая төгрөгийг авч зарцуулсан зөрчил илэрсэн.	5.7	Төлбөрийн акт	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Т.Ганзориг, С.Ганзориг
2	Өмнөх оны аудитаар 1 жилээс дээш насжилттай 53.1 сая төгрөгийн авлагыг барагдуулах зөвлөмжийн хэрэгжүүлээгүй	53.1	Албан шаардлага		
3	11.6 сая төгрөгийн цахим баримтын бүрдлийг хангаагүй зөрчил илэрсэн.	11.6	Албан шаардлага		
4	Тайлант онд худалдан авалтыг зохион байгуулаагүй 79.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн ба техникийн тодорхойлолт болон төсөвт өртгийг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс санал ирүүлэх оролцогчгүй болж шалгаруулалт амжилтгүй болсон байна	79.9	Албан шаардлага		
Амгалан дулааны станц ХХК					
5	Жолоочийн хариуцлагагүйн улмаас үүссэн 1.7 сая төгрөгийн өр төлбөрт хариуцлага ноогдуулж зохих арга хэмжээ авагдаагүй байна.	1.7	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Ш.Баянмөнх, Ч.Бямбаа
6	Санхүүгийн программ сайжруулалт хийлгэхээр 3.6 сая төгрөг шилжүүлж, программ нь СС-ын 2018 оны 47-р тушаалаар батлагдсан санхүүгийн программ хангамжийн шаардлагыг хангаагүй байна.	3.6	Албан шаардлага		
7	90 сая төгрөгийн өртөгтэй сэлбэг хэрэгсэл, 31.9 сая төгрөгийн багаж худалдан авалтыг шууд гэрээ байгуулан худалдан авалт хийсэн	121.9	Албан шаардлага		
8	НББ-д ашиглагдахгүй НБББББ-ийг Солид Юнит ХХК-аар 2019.12.13-ний өдрийн 124/2019 гэрээний дагуу 10.0 сая төгрөгөөр хийлгэж үр ашиггүй зардал гаргасан байна.	10.0	Төлбөрийн акт		
'Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК					
9	Хонхор дэд станцын диспетчерийн ажлын байрны ариун цэврийн өрөө, амрах өрөө, хэрэглээний халуун, хүйтэн ус, бохир, дулааны нэгдсэн системд холбох 138.8 сая төгрөгийн гэрээт ажлын гэрээг магадалшгүй ажил гүйцэтгэгдээгүй байхад санхүүжилтийг олгосон, захиалагчийн хяналтын зардлыг гүйцэтгэгч талд олгосон байна	4.6	Төлбөрийн акт	Гүйцэтгэх захирал, ХААХХ-ийн дарга	Г.Шүрэнчулуун, Б.Гүррагчаа

10	Тайланд онд 1,162.2 сая төгрөгийн Төмөр бетон тулгуур худалдаж авах ажлын нийлүүлэгч Си Эм Пи Ай ХХК-ийг сонгон шалгаруулахдаа техникийн тодорхойлолтод заасан тохирлын гэрчилгээгүй компани шалгаруулсан байна.	1,162.2	Албан шаардлага		
11	Зорилтот түвшний төлөвлөгөөнд тусгагдаагүй 217.0 сая төгрөгийн худалдан авалт хийсэн. Тайлант онд дахин автомашин худалдан авахаар худалдан авалтын төлөвлөгөөнд тусгаж 206.5 сая төгрөгөөр Ланд крузер-200 маркийн автомашин худалдан авахдаа ТӨБЗГ-аас зөвшөөрөл аваагүй байна.	423.5	Албан шаардлага		
'Багануурын дулааны станц ТӨХК					
12	Компанийн санхүүгийн тайланд 365-аас дээш хоногийн насжилттай нийт 22.7 сая төгрөгийн авлагын үлдэгдэл байна. Уг авлага нь 2018 онд шүүхийн шийдвэр гарч, Дүүргийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэст шилжсэн хэдий ч тайлант хугацаанд авлага буураагүй.	22.7	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал, СБХ-ийн дарга	Н.Ганбаатар, Ц.Энхцэцэг
'Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК					
13	Дараа тайлангаар ажилтанд олгосон томилолтын зардлын тооцоог гүйцэтгэл дутуу баримтаар 0.07 сая төгрөг илүү олгосон	0.1	Төлбөрийн акт	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Д.Ганхүлэг, Н.Отгонтунгалаг
14	Сахилгын шийтгэлтэй 4 ажилтанд ажилчдын сар бүрийн үйл ажиллагааны үр дүнгийн цалин 0.7 сая төгрөгийг тооцон олгосон	0.7	Төлбөрийн акт		
15	Гидроповер" ХХК нь засвар үйлчилгээ, аваарын сэлбэг хэрэгслийн нөөц бүрдүүлэх 60.0 сая төгрөгийн нээлттэй тендер шалгаруулалтад шалгарсан байна. Тус компани нь бараа бүтээгдэхүүн нийлүүлээгүй байгаа бөгөөд 10.0 сая төгрөгийг шилжүүлж авлага үүсгэн оны эцэст урьдчилж төлсөн зардал дансанд шилжүүлэн бүртгэсэн	10.0	Албан шаардлага		
16	2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд харьцуулалтын аргаар кадан утас 13.6 сая төгрөгөөр худалдан авахаар тусгасан ба гүйцэтгэлээр 11.0 сая төгрөгийн кадан утас худалдан авалт хийж 2.6 сая төгрөгийг ХАА-ны тайлангаар зөрүүтэй тайлагнасан	2.6	Албан шаардлага		
'Даланзадгадын ДЦС ТӨХК					
17	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлс болох 36,0 сая төгрөгөөс 3,6 сая төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгаагүй байна	3.6	Төлбөрийн акт	Гүйцэтгэх захирал, Нягтлан бодогч	Л.Банзрагч, С.Гэрэлт-Од
18	Санхүүгийн тайланд нэмэгдсэн өртгийн албан татварын өглөгийн үлдэгдлийг 33.1 сая төгрөгөөр дутуу тайлагнасан байна.	33.1	Албан шаардлага		

19	Даланзадгадын ДЦС-ын удирдлага нь ТУЗ-ын шийдвэрийг үндэслэн 2019 оны жилийн үр дүнгийн урамшууллыг 2020 оны 2 дугаар сард 193 хүнд 306.2 сая төгрөгийг 2.7 сараас 3 сараар тооцон хавтгайруулан олгосон байна.	306.2	Албан шаардлага		
Диспетчерийн үндэсний төв					
20	2015 онд ашиглалтад орсон Соната 8 автомашиныг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэрийн дагуу 20.0 сая төгрөгөөр засвар хийлгүүлж, 2020 оны 66/2020 актаар ажлын хэсэг хүлээн авч байгууллагаас төлбөрийг гүйцэтгэсэн нь өмнөх аудитын зөвлөмжөөр гэм буруутай этгээдэд хариуцлага тооцох гэснийг хэрэгжүүлээгүй байна.	20.0	Төлбөрийн акт	Гүйцэтгэх захирал, ЗУА-ны дарга, Ерөнхий нягтлан бодогч	Г.Балжинням, Б.Биндэръяа А.Цагаансар
21	Тайлант онд шатахууны зардал болон албан томилолтын зардалд нийт 1.0 сая төгрөгийн анхан шатны баримтын бүрдэлгүй зарлагыг хүлээн зөвшөөрсөн	1.0	Төлбөрийн акт	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Г.Балжинням, А.Цагаансар
22	Нэг худалдан авагчийн загварын тайланд тарифын зөрүүг өмнөх онд 11,508.1 сая төгрөгийн алдагдал, тайлант онд 8,058.9 сая төгрөгийн нөөцийн өр төлбөр тайлагнаж тарифын эерэг, сөрөг зөрүүг нэг ижил бүртгэлээр хөтлөөгүй, Эрчим хүчний сайдын 2018 оны 142 дугаар баталсан бүртгэл хөтлөх зааврыг хэрэгжүүлээгүй, журам гаргаж мөрдөөгүй, тарифын зөрүүг бүртгэх бүртгэлийн горимыг НБББББ-д тодорхойлоогүй	8,058.9	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал, харилцаа эрхэлсэн дэд захирал, Ерөнхий нягтлан бодогч	Г.Балжинням, Ц.Өнөрмаа, А.Цагаансар
23	Аваарын нөөцийн сэлбэг хэрэгслийг бэлтгэн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, гарсан зардлыг капиталжуулдаг. Тайлант оны эцэст үндсэн хөрөнгө дансанд бүртгэлтэй 67.0 сая төгрөгийн аваарын нөөцийн сэлбэг хэрэгслийн насжилт өндөр, НБББББ-т аваарын нөөцийг бүртгэх горимыг тодорхойлоогүй	67.0	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч, Үндсэн хөрөнгийн нягтлан	Г.Балжинням, А.Цагаансар, Д.Сэндэрмаа
'Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК					
24	Тайлант оны 12 дугаар сарын орлогыг орлогоор хүлээн зөвшөөрч тайлагнаагүй орхигдуулсан	612.5	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Г.Отгонбаатар, Д.Гэрэлчулуун
'Дулаан шарын гол ТӨХК					
25	Үр дүнгийн шагнал олгох шалгуур хангагдаагүй байхад ажиллагсад сар бүр үр дүнгийн шагнал нийт 37.7 сая төгрөгийг хавтгайруулан олгосон.	37.7	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Б.Батхуяг, Ж.Даш
'ДЦС-2 ТӨХК					

26	1. Эрчим хүчний болон бусад салбарын “Тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагнагдсан 121 ажилтан, 152 ахмад ажилтнуудад сар бүр 10.0 мянган төгрөгөөр тооцон тайлант онд нийт 27.8 сая төгрөгийн урамшууллыг үндэслэлгүйгээр олгосон, 2. Халаалтын улирлын хөнгөлөлтийг орон сууцанд амьдардаг ажилтнуудад жилд нэг удаа 100.0 мянган төгрөгөөр тооцон нийт 149 ажилтанд 14.9 сая төгрөгийг олгосон,	42.7	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Ц.Минжинхүү, О.Энхбаяр
'ДЦС-3 ТӨХК					
27	ХУД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 183/2019/02010 дугаар шийдвэрээр ажилдаа эргэн орсон ажилтанд ажилгүй байсан хугацааны нөхөн олговор нийт 17.7 сая төгрөгийн зардал гаргасныг буруутай албан тушаалтнаар төлүүлээгүй байна.	17.7	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Ч.Чинбат, Ц.Лхамсүрэн
'ДЦС-4 ТӨХК					
28	Хэмжих хэрэгслийн сэлбэг худалдан авах тендерийн шалгаруулалт хийхдээ тендерийн бичиг баримтын зөрчилтэй компанийг шалгаруулсан байна.	255.0	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Ү.Төмөрхуяг, Д.Төмөртоого
'Налайхын ДЦС ТӨХК					
29	Ажлаас халагдсан хүнд илүү цалин бодож олгосон	0.6	Төлбөрийн акт	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Ц.Энхтүвшин, Д.Бадамлянхуа
30	Өмнөх аудитын зөвлөмжөөр өгөгдсөн авлагыг барагдуулаагүй	64.2	Албан шаардлага		
'Тавантолгой түлш					
31	Таван толгой түлш ХХК нь Эрдэнэс монгол ХК-ийн ТУЗ-ын 2018 оны 23 дугаар тогтоолын дагуу Эрдэнэс монгол ХК-ийн 100 хувийн эзэмшлийн охин компани хэлбэрээр байгуулагдсан боловч санхүүгийн тайлан нь толгой компанид нэгтгэгддэггүй, мөн ТУЗ-ийн 2018 оны 47 дугаар тогтоолоор Эрдэнэс таван толгой ХК-д шилжсэн боловч Улсын бүртгэлийн гэрчилгээ болон компанийн дүрэмд өөрчлөлтийг бүртгүүлээгүй байна.	-	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	М.Ганбаатар, П.Амарцэцэг
32	Засгийн газрын 2020 оны 200 дугаар тогтоолд заасны дагуу сайжруулсан шахмал түлшний үнийн зөрүүг гүйцэтгэлээр нь Эрдэнэс таван толгой ХК санхүүжүүлэхээр болсон ч авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	-	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	М.Ганбаатар, П.Амарцэцэг
33	Санхүүгийн тайланд тусгагдсан нийт 6,299.5 сая төгрөгийн авлагын 50 хувийг барьцалдуулагч түүхий эд материалын авлага эзэлж байна.	-	Албан шаардлага		
34	НАБТГ-аас Таван толгой түлш ХХК-ийн гэрээт борлуулагчдын борлуулалтын урамшууллыг	-	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал,	М.Ганбаатар, П.Амарцэцэг

	санхүүжүүлэхдээ ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг дутуу олгосноос нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүсэж, цаашид хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй байна.			Ерөнхий нягтлан бодогч	
35	Нягтлан бодогчийн ажлын ачааллаас шалтгаалан цалингийн тооцоолол, бичилт, тайлагналтай холбоотой 72.4 сая төгрөгийн залруулаагүй алдаа зөрчил илрээд байна	72.4	Албан шаардлага		
36	Өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлэлгүй Засгийн газрын 2018 оны 18 дугаар хурлын тэмдэглэлийг үндэслэн ЗГХЭГ-аас гаргасан хүсэлтийн дагуу Энержи ресурс ХХК-иас үнэ төлбөргүй нийлүүлж байгаа угаасан нүүрс буюу мидлингийн өртгийг Өмнөговийн Улаанбаатар хүртэлх тээврийн хөлсөөр бүртгэж, үндсэн түүхий эдийн үнийг өртөгт тусгаагүй байна.	-	Албан шаардлага		
'Тавантолгойн цахилгаан станц ХХК					
37	Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар 0.7 сая төгрөгийн гүйлгээг кассаас олгож бүртгэсэн байна.	0.7	Төлбөрийн акт	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Г.Тэнгэр, Э.Болор-эрдэнэ
'Увсын дулааны станц ТӨХК					
38	57.7 сая төгрөгийн худалдан авалтын и-баримт цахим системд бүртгэлгүй байна.	57.7	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Б.Мөнгөн, Н.Сарнай
'Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК					
39	Шатахууны үнийг гэрээнд заасан үнээр тооцолгүй зах зээлийн үнээр худалдан авалт хийж нийт 38.2 сая төгрөгийг илүү шилжүүлсэн.	38.2	Төлбөрийн акт	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Р.Дагдан, О.Ариунболд
40	Өмнөх оны аудитаар бэлтгэн нийлүүлэгчээс авах 433.3 сая төгрөгийн авлагыг барагдуулах төлбөрийн акт тогтоосныг компанийн хөрөнгөөс барагдуулж, бэлтгэн нийлүүлэгч компаниудаас авлагыг цуглуулаагүй байна.	0.0	Албан шаардлага		
41	Бэлтгэн нийлүүлэгчтэй холбоотой 7 харилцагчийн 62.8 сая төгрөгийн авлага, 85 харилцагчийн 3,691.2 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, үүний 62.8 сая төгрөгийн авлага, 418.5 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэл насжилт өндөртэй байна.	3,754.0	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Р.Дагдан, О.Ариунболд
42	Өмнөх онд 69.0 сая төгрөгийн 10 ширхэг шугамын гэмтэл заагчийг худалдан авсан боловч уг программ нь шаардлага хангахгүй, ашиглах боломжгүй бараа материал хүлээн авсан байна.	69.0	Албан шаардлага		

43	Засгийн газраас баталсан аргачлалын дагуу үнэлж биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх 51,747 метр квадрат 14 газар эзэмших эрхийг санхүүгийн тайланд тусгаагүй, мөн 810 ширхэг цахилгааны барилга байгууламжид хамаарах газрын кадастрын зургийг хийлгэсэн боловч газрын гэрчилгээг гаргуулан аваагүй	-	Албан шаардлага		
44	Чингэлтэй хэрэглэгчдэд үйлчлэх төвийн оффис бүхий ажилтнуудын орон сууц"-ны төслийн үндсэн зорилгыг хангахгүйгээр нэр бүхий 3 ажилтанд тус бүр 2 орон сууц борлуулсан, мөн тавигдах шаардлагад нийцээгүй 1 ажилтанд орон сууцыг худалдсан зэрэг тэгш, хүртээмжтэй хуваарилаагүй байна.	-	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Р.Дагдан, О.Ариунболд
45	Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 274.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл арга хэмжээний тендерийн баримт бичигт заасан шаардлагын дагуу үнэлгээг үнэн зөв хийгээгүй. Мөн тендер шалгаруулалтын журам мөрдөөгүй 462.2 сая төгрөгийн худалдан авах аргаар сонгон шалгаруулсан байна.	736.7	Албан шаардлага		
'Хөвсгөл дулааны станц ТӨХК					
46	Хөвсгөл аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020.09.07-ны 155шш2020/01637 шийдвэрээр ажилдаа эргэн орсон ажилтанд ажилгүй байсан хугацааны нөхөн олговор нийт 6.3 сая төгрөгийн зардал гаргасныг буруутай албан тушаалтнаар төлүүлээгүй байна.	6.3	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Д.Цанлигрэнчин, В.Мөнгөнцэцэг
'Эрдэнэт Булганы ЦТС ТӨХК					
47	Босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтаас зайлсхийж төсөвт өртгийг хувааж төлөвлөн, нээлттэй тендер шалгаруулалтын журам мөрдөгдөх төсөл арга хэмжээг харьцуулалтын аргаар, харьцуулалтын аргын журмын мөрдөгдөх төсөл арга хэмжээг шууд худалдан авах аргаар нийт 231.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 бүлэг бүхий 11 төсөл арга хэмжээний худалдан авалтыг журмыг буруу сонгон гүйцэтгэсэн.	231.3	албан шаардлага	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Г.Баярцогт, Б.Наранцэцэг
'Эрчим хүчний хөгжлийн төв ТӨААТҮГ					
48	НБББББ-т 2013 оноос хойш өөрчлөлт хийгдээгүй хэвээр, өмнөх аудитын өгсөн зөвлөмж хэрэгжээгүй байна	0.0	албан шаардлага	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Я.Нямжаргал, Д.Эрдэнэчимэг
'Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн					

49	Тус хүрээлэнгийн гүйцэтгэх захирал нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргатай хийсэн контрактын гэрээний 4.2 заалтыг зөрчиж өөртөө 27.9 сая төгрөгийн цалин урамшил олгосон байна	27.9	албан шаардлага	Гүйцэтгэх захирал, Ахлах нягтлан бодогч	М.Түмэнжаргал, Б.Роломжав
50	Эрчим хүчний салбарын стандарт орчуулах 41.0 сая төгрөгийн тендерийг цахимаар зарлаагүй, худалдан авалтын төлөвлөгөөнд тусгаагүй байна	41.0	албан шаардлага		
51	Тайлант онд мэргэжлийн үйлчилгээний зардалд зарцуулсан 46.5 сая төгрөгийн ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа харьцуулалтын аргыг хэрэглээгүй байна	46.5	албан шаардлага		
52	Тайлант онд Эрчим хүчний яамны сайд, дэд сайд, төрийн нарийн бичгийн даргын хэрэгцээнд 15.2 сая төгрөгийн шатахууны, конторын үйлчилгээний зардал буюу цайны зардал 6.9 сая төгрөгийг зарцуулсан байна	22.1	албан шаардлага		
Эрчим хүчний яам-аппарат					
53	Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 12 дугаар сарын 28-ний өдрийн Б/282 дугаар тушаалаар нийт ажилтнуудад 3 сар хүртэлх хугацааны үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 200.8 сая төгрөгийн урамшууллыг давхардуулж олгосон байна	200.8	Албан шаардлага	Төрийн нарийн бичгийн дарга, Санхүүгийн хэлтсийн дарга	Б.Насантогтох Ж.Жанарбаатар
54	Төсөвт зохицуулалт хийх зөвшөөрөлгүйгээр зардлын эдийн засгийн ангиллын бүлэг хооронд нийт 48.3 сая төгрөгийг гүйлгэн зарцуулсан байна.	48.3	Албан шаардлага		
55	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд бий болсон Булган аймгийн дулааны станцын байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисс ажиллаж 2019 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 41/2019 дугаартай акт үйлдэн хүлээн авсан барилга байгууламжийг ТӨБЗГ-аар өмч эзэмшлийн хувь тогтоогдоогүйгээс ашиглагч байгууллагуудад шилжүүлээгүй байна	-	Албан шаардлага	Төрийн нарийн бичгийн дарга, Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга	Б.Насантогтох А.Энхбат
Нийт дүн		16,787.0			